



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
САЛБАР ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2017 оны 11 сарын 15 өдөр

Дугаар 21

Арвайхээр

Салбар комисс байгуулах тухай

Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 86 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлагдсан “Төрийн жинхэнэ албан тушаалд анх ороход мэргэшлийн шалгалт авах журам”-ын 1.4.2, 5, 6 дугаар дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний мэргэшлийн шалгалтын аймгийн салбар комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга: Ц.Ганболд (Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөлийн дарга)

Нарийн бичгийн дарга: Э.Бадамгэрэл (Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга)

Гишүүд: Л.Ламаачин: (Аймгийн Ерөнхий аудитор, Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн гишүүн)

Н.Энхцэцэг (Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга, Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөлийн гишүүн)

С.Дуламсүрэн (Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын дарга, Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн гишүүн)


В.Шоовдор (Арвайхээр сумын Засаг даргын Тамгын газрын дарга, Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөлийн гишүүн)

Д.Мөнхбаяр (Аймгийн Шүүхийн Тамгын газрын дарга, Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн гишүүн)

2. Төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний мэргэшлийн шалгалтыг цахимаар хийж, шалгалт авах байр, компьютер, интернэтийн сүлжээ, эрчим хүчний найдвартай байдлыг бий болгож, шалгалт зохион байгуулах хэвийн нөхцөл байдлыг ханган ажиллахыг Салбар комиссын комисс (Ц.Ганболд)-д үүрэг болгосугай.

3. Төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний мэргэшлийн шалгалтын дүнг 2017 оны 11 дүгээр сарын 22-ны дотор нэгтгэн Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлж, дүнг Төрийн албаны зөвлөлд хүргүүлэхийг Салбар комиссын нарийн бичгийн дарга (Э.Бадамгэрэл)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ГАНБОЛД

03 - -0041